

ХЭЛЭХ АЯЛГА, ЗЭРЭГЦҮҮЛЭН ХОЛБОХ
ҮГ, НӨХЦӨЛ НЬ ЗЭРЭГЦҮҮЛЭН ХОЛБОХОД
ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ БАЙГААГ ТОДРУУЛАН,
ЗЭРЭГЦСЭН НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭРИЙН
НАЙРУУЛГЫН ҮҮРГИЙГ ТАЙЛБАРЛАХ

7-р анги

Хичээлийн зорилго

- Гадаад ба дотоод шинжийг дүрслэн тоочин бичихэд зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн үүрэг чухал байгааг тодруулах

Зэрэгцүүлэн холбох үг нөхцөлийн хэрэглээ

Түүнтэй би одоогоос арван хэдэн жилийн тэртээ танилцсан билээ.

Өнөөгийн ардын жүжигчин С.Мягмарнаран театрын гадна гансарч, Ц.Гантөмөр гэртээ муур тэжээж, нэрт жүжигчин О.Нямсүрэн, Н.Сувд нар багшилж, Б.Цэрэнпагма хөдөө хээр тэнэж явсан үе байв даа. Киноны ертөнцийн нэрт хатагтай Б.Цэрэнпагма гомдож тунилгүй гүдэсхэн зангаар театрынхаа хаалгыг хааж, сураг ажиггүй алдран одсон тэр хатагтайн араас уйгагүй эрж хайх ажилд орлоо.

Өгүүлбэрийг ажиглая

Өнөөгийн ардын жүжигчин С.Мягмарнаран театрын гадна гансарч, Ц.Гантөмөр гэртээ муур тэжээж, нэрт жүжигчин О.Нямсүрэн, Н.Сувд нар багшилж, Б.Цэрэнпагма хөдөө хээр тэнэж явсан үе байв даа.

Цаг хугацааг мэдэхэд -ж, ч нөхцөл ямар үүрэгтэй байна вэ?

- Үйл явдал нэг цагт зэрэгцэн болж байгаа утгыг илэрхийлэхдээ -Ж,-Ч нөхцөлүүдээр холбосон байна.

Өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задлаж үзье

1. Өнөөгийн ардын жүжигчин С.Мягмарнаран театрын гадна гансар**ч**,
2. Ц.Гантөмөр гэртээ муур тэжээ**ж**,
3. Нэрт жүжигчин О.Нямсүрэн, Н.Сувд нар багшил**ж**,
4. Б.Цэрэнпагма хөдөө хээр тэнэж явсан үе байв даа.

Өгүүлбэр

Энгийн өгүүлбэр \нэг санаа, болон нэг үйл явдлыг илэрхийлнэ.\

Нийлмэл өгүүлбэр \хэд хэдэн санаа, үйл явдлыг илэрхийлнэ.\

Цөм өгүүлбэр

- 2 бүрэлдэхүүнт
- 3 бүрэлдэхүүнт

Цөм бус өгүүлбэр

ЗНӨ

УНӨ

ХОНӨ

Өгүүлбэрүүдийн үйл явдлын байрыг солиход цагийн утгад өөрчлөлт гарч байна уу? Үйлийн эзнийг олж бичье

Хэн ? ... театрын гадаа
гансарч

Хэн?... гэртээ муур
тэжээж

Хэн?... нар багшилж

Үйлүүд өөр өөр
эзэнтэй байна.

Хэн?...үе байв.

Нэг нь нөгөөдөө захирагдахгүй зэрэгцүүлэн холбох янз бүрийн арга байдгийг харъя

1. Дуурийн театрын үүдэнд зогсон, түүний ирэхийг хүлээв.
“Дуурийн театрын үүдэнд зогсон”, “түүний ирэхийг хүлээв.”
2. Зураг авалтын дараа сэтгэл хэзээ ч байгаагүйгээр ханаж, ахиад юунд ч шунахааргүй цатгалан амьтан болчихсон шүү.
“Зураг авалтын дараа сэтгэл хэзээ ч байгаагүйгээр ханаж”,
“ ахиад юунд ч шунахааргүй цатгалан амьтан болчихсон шүү”
гэсэн бие биеэ үл захирах , тэгш эрхтэй хоёр үйл явдал зэрэгцжээ.
3. **Бас** л сайхан хүүхэн юм аа... Уруул дээрх мэнгэ, инээхэд нь ярс хийх цагаан шүд , илүү дутуу хиймэл зан авиргүй байгаагаараа... гэхэд “бас” холбох үг болон хэлэх аялгаар холбогдсон.

\ярианд зогсосхийлт, бичигт таслалаар тэмдэглэдэг.\

Өгүүлбэрүүдийн холбоосыг ажиглан ЗНӨ хэрхэн бүтсэнийг тодруулъя

- Морь нь усан хулгана шиг болж, хөх мах нь чичрэн, нүдний ухархайнаас нь хүртэл хөлс дусалж байв .
- Монгол дээл голдуу өмсөх боловч европ хувцас холимог хэрэглэдэг.
- Нөхөр Нацагдорж зан ааш дөлгөөн даруу, үг цөөн , үерхэг нөхөрсөг, дуурайлтай, ихэрхэг бардам зан огт байхгүй.

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

Хоёр ба түүнээс дээш энгийн өгүүлбэр нэг нь нөгөөгөө захирахгүй, тэгш эрхтэй холбогдож, утга , бүтэц, аялгын хувьд нэгдмэл болсныг ЗНӨ гэнэ.

Жишээ нь: Морь нь усан хулгана шиг болж, хөх мах нь чичрэн, нүдний ухархайнаас нь хүртэл хөлс дусалж байв .

1. Морь нь усан хулгана шиг болж
2. Мах нь чичрэн
3. Хөлс дусалж байв.

- Дээрх өгүүлбэр нь 3 энгийн өгүүлбэрээс бүтсэн.
- Өгүүлэхүүн тус бүр үйлийн эзэнтэй.
- Үйлийн зэрэгцүүлэн холбох -Ж , хам холбохын –Н нөхцөлөөр холбогдсон.
- Үйл явдал нэг цагт зэрэгцэж болсон утга илтгэсэн.
- Өгүүлбэрүүд нь бие биедээ захирагдахгүй тэгш эрхтэй .

ЗНӨ –ийн онцлог

- Хоёр ба түүнээс дээш ЭӨ-ээс бүтнэ.
- Өгүүлэхүүн тус бүр үйлийн эзэнтэй
- Үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдоно
- Үйл явдал зэрэгцэж нэг цагт болсон утга илтгэнэ.
- Өгүүлбэрүүд нь өөр хоорондоо тэгш эрхтэй холбогдох тул байрыг нь солих боломжтой.
- Өгүүлбэрүүд нь нэг нь нөгөөгөө захирахгүй.
- Өгүүлбэрийн хэсгүүдийн зааг ялгаа тодорхой байдаг тул тус тусдаа энгийн өгүүлбэр болж амархан салдаг.

ЗНӨ- ийн холбох хэрэглүүр

- **Нөхцөлдүүлэн холбохын зэрэгцүүлэн холбох утгатай** -ж,- ч,- аад,- ээд,-оод,-өөд, -саар,-сээр,-соор,-сөөр, - вч нөхцөлүүдээр холбогдоно.
- **Зэрэгцүүлэн холбох үгээр:** ба,болон, боловч, бөгөөд, буюу, хийгээд, агаад, эсвэл, аль эсвэл, атал, төдийгүй, байтугай, түүгээр барахгүй, үл барам, түүгээр зогсохгүй,түүнчлэн, харин, бас, төдийгүй, бол, зэрэгцээ, гадна мөн гэх мэт.
- **Хэлэх аялга буюу тэг холбоосоор холбогдоно.** \ярианд зогсосхийлт, бичигт таслалаар тэмдэглэдэг.\

ЗНӨ-ийн найруулгын үүрэг

- Тоочимж эх бүтээнэ.
- ЗНӨ нь хүн юм үзэгдлийн гадаад төрх байдал, дотоод мөн чанар, үйл хөдлөл, бодит байдлыг тодорхой нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрслэхэд, найруулгад тэгш хэм бүтээхэд чухал үүрэгтэй.

Жишээ нь: 1. Намрын шөнийн одод гялалзаж, чийглэг сэрүүн агаар нуруу жиндүүлнэ. \Нөхцөлдүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон ЗНӨ\

2. Хөвчид цас зузаан орсон **боловч** яг энүүхэн хавьдаа газар хар, **хагд өвс халиурна.** / АБ өгүүлбэр нь зэрэгцүүлэн холбох үг, БВ өгүүлбэр нь аялга буюу тэг холбоосоор холбогдсон ЗНӨ байна./

3. Хөрөнгө баялгаас цатгалан сэтгэлгээ төрдөг.

Цатгалан хүнээс ямагт бүдүүлэг авир гардаг. \Тэг холбоосоор холбогдсон ЗНӨ /